## САНХҮҮ, БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**2025.05.21**

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 1: Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ. | | | | | | | |
| 1.1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.3,5-т заасан "Цахим шилжилтэд бүрэн шилжинэ" зорилтын хүрээнд | | | | | | | |
| 1.1.1 | МУТЖҮЧ-2.2.5, ЭМДС-ийн орлого, зарлага, төсвийн гүйцэтгэлд Fiscus программаар хяналт тавих, дашборд хөгжүүлж, олон нийтэд мэдээлнэ | - | Программ хангамжид шинээр хөгжүүлсэн модулийн тоо,<br>-Олгосон санхүүжилтийн тоо | Fiscus программыг HIGS програмттай бүрэн холбогдсон. | ЭМБ, эмийн санд олгосон санхүүжилтийн нэгтгэл мэдээллийг HIGS системээр дамжуулан ил тодоор мэдээллэдэг болсон байна. | Эрүүл мэндийн даатгалын сангаас тусламж, үйлчилгээний санхүүжилт авсан эрүүл мэндийн байгууллагуудын олгосон санхүүжилтийн нэгтгэлийг DASH WORD програмд 2022-2024 оны олгосон, олгохоор тооцсон санхүүжилтийн мэдээллийг EXCEL файл бэлдэн БТГазарт хүргүүлсэн.<br>Мөн ЭМДС-ийн орлого, зарлага, төсвийн гүйцэтгэлд Fiscus программаар хяналт тавих, дашборд хөрвүүлэхээр БТГ, МТХ хамтран ажиллаж байна.<br>Үр дүн: Дашборд хөгжүүлж, олон нийтэд мэдээлэл хүргүүлэх | 70 |
| 1.1.2 | Төлбөрийг төр хариуцах эм болон нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг цахим системээр хүлээн авч, хянаж, олгодог тогтолцоог бүрдүүлнэ. | | Шинээр хөгжүүлсэн програм | Цаасан суурьт нэхэмжлэлийг хүлээн авч хянадаг. | Төлбөрийг төр хариуцах эм болон нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг цахим системээр хянадаг болсон байна. | Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүгийн "FISCUS" програм, "HICS" програмтай холбогдож тухайн сарын тусламж, үйлчилгээний нэхэмжлэл, олгохоор тооцсон санхүүжилтийн гүйцэтгэл санхүүгийн "FISCUS" програмд тусламж, үйлчилгээ бүрээр татагдаж байна.<br>Анхан шатны нэг иргэний 2025 оны төсөв болон 20 хувийн гүйцэтгэлийг "HICS" програмаас санхүүгийн "FISCUS" програмд татагдаж хяналтыг сайжруулж байна.<br>ЭМДҮЗ-ийн 2025 оны 04 дүгээр тогтоолын өөрчлөлтийн дагуу төлбөрийг төр хариуцах эмийн нэхэмжлэлд хяналт хийхээр "HICS" программд дахин бодолт хийж байгаа тул санхүүгийн програмд гүйцэд орж ирээгүй байна. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Үр дүн: Цахим системын хяналт сайжрана. | |
| 1.2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.4-т заасан “Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно" зорилтын хүрээнд | | | | | | | |
| 1.2.1 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг хангаж ажиллана. | | Хэрэгжилтийн хувь | 100 хувь | 100 хувь | 2025 оны 05 дугаар сарын 20-ний байдлаар санхүү бүртгэлийн хэлтэстэй холбоотой хяналтад авсан хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтийг Тамгын газарт цаг хугацаанд нь гаргаж өгөхөөр бэлдэж байна.<br>Үр дүн: Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг хангаж ажилласан. | 90 |
| 1.2.2 | Холбогдох хууль болон дүрэм, журам, тогтоолын шинэчлэлд санал хүргүүлнэ | | Хүргүүлсэн санал | | Холбогдох хууль болон дүрэм, журам, тогтоолд санал хүргүүлсэн байна. | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн батлах “Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг бүрдүүлэх, цуглуулах, төвлөрүүлэх журам”, “Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагчийн мэргэшлийн зэрэг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох журам”-д тус тус саналаа боловсруулан холбогдох газруудад хүргүүлсэн.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газартай хамтарсан 2025 оны "ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ"-нд саналаа хүргүүлсэн. Мөн 2024 оны хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн дүгнэлтэнд саналаа өгсөн.<br>Үр дүн: Журам, тогтоолд санал хүргүүлсэн. | 90 |
| Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 2: Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлогыг нэмэгдүүлж, үзүүлэх тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, хүрээг өргөтгөнө. | | | | | | | |
| 2.1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1-т заасан “Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлого, тусламж, үйлчилгээний тоо хэмжээ нэмэгдүүлнэ" зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 2.1.1 | ЭМДТХ-9.1.9, “Алсын хараа 2050” МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7<br><br>Эрүүл мэндийн | | Шинэчлэн батлагдсан журам<br><br>-ЭМД-ын шимтгэлийн хувь<br><br>-Бүрдүүлсэн | -Төр хариуцах иргэдийн шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр 0-18 насны хүүхдийн даатгалын шимтгэлийн | -Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ нэмэгдсэн байна.<br><br>-ЭМД-ын орлого 95 хувиас доошгүй | Засгийн газрын 2025 оны 02 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2025 оны хэмжээ”-г шинэчлэн тогтоосны дагуу хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангах, хамрах хүрээг өргөтгөх, сангийн орлогын бүрдүүлэлтийг сайжруулах зорилгоор төрийн байгууллагуудтай “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулан, гэрээний | |

<table>
<tr>
<td></td>
<td>даатгалын санд төр хариуцан төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг өөрчлөн нэмэгдүүлэх санал хүргүүлэх, орлогын бүрдүүлэлт, зарцуулалт-ыг оновчтой болгох журмыг шинээр боловсруулж, батлуулж хэрэгжүүлнэ.</td>
<td></td>
<td>орлогын хэмжээ<br><br>-<br>Хамрагдалтын хувь</td>
<td>хэмжээг 2 хувь болгох саналыг ЭМЯ-нд хүргүүлсэн.<br>-Төр хариуцах иргэдийн шимтгэлийн 2024 оны орлого 324.1 тэрбум төгрөг ЭМДСанд төвлөрсөн. ЭМДС-ийн төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр сангийн орлого 1925.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 98.0% байна. 2024 онд ЭМД-д хамрагдсан иргэдийн хувь 93%.</td>
<td>байна.<br><br>-Хамралтын хувь 95%-аас доошгүй байна.</td>
<td>хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Эрүүл мэндийн даатгалд 2025 оны 04 дүгээр сарын 30-ны байдлаар давхардсан тоогоор 3103.1 мянган даатгуулагч хамрагдсан байна.<br>Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцах иргэдийн мэдээллийг “Төр хариуцах иргэдийн бүртгэлийн программ”-д бүртгэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг цаг алдалгүй авах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.<br><br>Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар эрүүл мэндийн даатгалын сангийн нийт орлогыг 2514.8 тэрбум төгрөгөөр баталсан бөгөөд 2025 оны 04 дүгээр сарын 30-ний байдлаар 822.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрөөд байна.<br>ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО /тэрбумтөгрөг/
<table>
<tr><th>№</th><th>Орлогын төрөл</th><th>2025 оны төлөвлөгөө</th><th>Гүйцэтгэл</th><th>Биелэлт /хувь/</th></tr>
<tr><td>1</td><td>НДЕГ-аас</td><td>307.3</td><td>275.0</td><td>89.0</td></tr>
<tr><td>2</td><td>Төр хариуцах иргэдийн шимтгэл</td><td>117.7</td><td>117.7</td><td>100</td></tr>
<tr><td>3</td><td>ЭМЯ-аас Төсвийн санхүүжилт</td><td>412.1</td><td>412.1</td><td>100</td></tr>
<tr><td>4</td><td>ЭМДШ-н орлого</td><td>16.6</td><td>16.5</td><td>99.0</td></tr>
<tr><td>5</td><td>Бусад орлого акт, торгууль</td><td></td><td>1.3</td><td></td></tr>
<tr><td>6</td><td>Ташаарсан орлого</td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td>Нийт дүн</td><td>853.7</td><td>822.4</td><td>96.0</td></tr>
</table>
Үр дүн: ЭМДС-д 2025 оны 04 дүгээр сарын 30-ний байдлаар 822.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн байна</td>
<td>80</td>
</tr>
<tr>
<td>2.1.2</td>
<td>БСТ -2.1.3<br>Эрүүл мэндийн даатгалын сангийн авлагыг барагдуулах ажлыг хууль</td>
<td>-</td>
<td>Сан төвлөрүүлсэн мөнгөн дүн</td>
<td>Капитал банкнаас 2024 онд 13.2 тэрбум төгрөг төвлөрүүлсэн. 10.5 тэрбум</td>
<td>УДШ-ийн шийдвэрийн хэрэгжилт, ЭМДҮЗ-ийн 2021 оны 11 дүгээр тогтоолын</td>
<td>Тамгын газартай хамтран Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай мэдээлэл солилцон, нягт холбоотой хамтран ажиллаж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас Чингис хаан банкны өр төлбөрт санал болгосон 13 обьект,</td>
<td>70</td>
</tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хяналтын байгууллагатай хамтран шийдвэрлүүлнэ. | | | төгрөгийн үл хөдлөх хөрөнгийн борлуулалтын орлого ЭМД-ын санд төвлөрч, Капитал банкны авлага 76.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. | хэрэгжилтийг хангуулах чиглэлээр хууль хяналтын байгууллагатай хамтран ажилласан байна. | Капитал банкны эрх хүлээн авагчаас санал болгосон 8 обьектыг хүлээн авах эсэх асуудлаар дүгнэлт гаргаж ажиллалаа. Санал болгосон үл хөдлөх хөрөнгүүд нь чанарын шаардлага хангахгүй, зах зээлийн үнээс хэт дээгүүр тогтоогдсон, худалдан борлуулах, түрээслэхэд хүндрэлтэй обьектууд байсан болно.<br>Чингис хаан банкны өр барагдуулах чиглэлээр Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Хөгжлийн банк, Нийгмийн даатгалын ерөнхий газрын хамтарсан ажлын хэсгийг гаргаж, ажлын төлөвлөгөө боловсруулан, цаашид авах арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна.<br><br>Үр дүн: Төлөвлөгөө гарган хамтран ажиллаж байна. | |
| 2.1.2 | Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага, төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж, эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг гаргана. | ЭМДС | Нэгтгэсэн мэдээ, тайлангийн тоо | ЭМДС-н 2024 онд 2025.8 тэрбум төгрөгийн орлого орсон байна.<br>ЭМДС-н 2024 онд 2035.4 тэрбум төгрөгийн зарлага гарсан байна.. | Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ 12, тайланг хуулийн хугацаанд 4 удаа гаргасан байна. | Эрүүл мэндийн даатгалын сан, байгууллагын санхүүгийн тайлан, мэдээг холбогдох хууль, журамд нийцүүлэн, тогтоосон хугацаанд нэгтгэн гаргаж, бүртгэлийн стандартын дагуу холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан.<br>Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг ҮАГ-ын аудитын газарт хүргүүлэн, санхүүгийн Аудитлагдсан тайланг хүлээн авсан.<br>Мөн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн улирлын болон сарын мэдээ, 2024 оны жилийн төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд цахим хуудсанд байршуулсан.<br><br>Үр дүн: Санхүүгийн тайлан, мэдээг хуулийн хугацаанд тайлагнасан. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.3 | Санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн хуулийн хугацаанд тайлагнаж, холбогдох байгууллагуудад хүргүүлнэ. | ЭМДС | Аудитлагдсан тайлан | 100 хувь тайлагнасан. | Аудитлагдсан тайлан гарсан байна. | Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг ҮАГ-ын аудитын газарт хүргүүлэн, санхүүгийн Аудитлагдсан тайланг хүлээн авсан.<br>Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны жилийн эцсийн урсгал санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн данснуудын хоорондын тооцоог орлого, зарлага, нэр данс зөрүүтэй гүйлгээ тус бүрээр тулган баталгаажуулалт хийж санхүүгийн тайланг олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу үнэн зөв гарган ҮАГ, СЯ, ЭМЯ, ЭМДҮЗ-д хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан.<br>Төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 1-4 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хуулийн хугацаанд гарган Сангийн яам, Төрийн сан, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар, Эрүүл мэндийн яам, ЭМДҮЗ цахим болон цаасаар баталгаажуулан хүргүүлэн ажиллаж байна. Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2024 оны дөрөвдүгээр улирлын санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу гаргасан.<br>Эрүүл мэндийн сайдын 2022 оны "Бүртгэл, тайлангийн маягтыг шинэчлэн батлах тухай" А/355 тоот тушаалын маягтын дагуу 21 аймаг болон Багануур, Налайх дүүргийн эрүүл мэндийн даатгалын хэлтсүүдээс 2024 оны жилийн эцсийн тайланг хүлээн авч нэгтгэсэн.<br>Э-Тайлан системд давхардсан тоогоор 1223 байгууллагын 3110.0 тэрбум төгрөгийн хоорондын тооцоо үүсгэж баталгаажуулалт болон устгах бичилт хийсэн. Сангийн яам, Эрүүл мэндийн яамтай үлдэгдлийг тулган баталгаажуулсан.<br>Эрүүл мэндийн даатгалын сангаас нийслэл болон орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад олгохоор тооцсон болон олгосон санхүүжилтыг | |

хоёр талдаа орлого, зарлагаар хүлээн зөвшөөрч өглөг авлагыг тооцоо нийлэн баталгаажуулан хоорондын тооцоо үүсгэн ажилласан. Үүнд:

1. Санхүү байдлын тайлан – 413 ЭМБ-н 223,6 тэрбум төгрөг

- Үр дүнгийн тайлан– 405 ЭМБ-н 1461,2 тэрбум төгрөг
- Мөнгөн гүйлгээний тайлан–405 ЭМБ-н 1425,2 төгрөг:

Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан 2024 ОН

/сая.төгрөг/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 279,911.79 | 365,968.55 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 161,057.09 | 155,871.50 |
| 33 | АВЛАГА | 80,227.27 | 169,174.00 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 994.25 | 5,168.56 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 37,633.19 | 35,754.50 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 7,297.81 | 7,123.81 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 7,297.81 | 7,123.81 |
| 39200 | Биет хөрөнгө | 3,003.94 | 3,323.94 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 4,293.87 | 3,799.87 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 287,209.60 | 373,092.37 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 218,321.67 | 316,851.36 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 218,321.67 | 316,851.36 |
| 41300 | Өглөг | 218,317.26 | 316,844.61 |
| 41400 | Урьдчилж орсон орлого | 4.40 | 6.75 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 68,887.93 | 56,241.01 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 68,887.93 | 56,241.01 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 13.79 | 13.79 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 68,874.14 | 56,227.21 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 287,209.60 | 373,092.37 |

Үр дүн: Санхүүгийн тайлан, мэдээг хуулийн хугацаанд тайлагнасан.

2.2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний Зорилт-2.2 Даатгалын сангийн тогтвортой байдлыг хангаж, эрсдэлээс хамгаалах зорилтын хүрээнд.

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.1 | БСТ- 2.2.1 Даатгалын сангийн эрсдэлд орсон мөнгөн хөрөнгийг төрийн санд төвлөрүүлэх, авлага барагдуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авна. | - | Барагдуулсан мөнгөн дүн | ЭМДҮЗ-н 2020 оны 08 дугаар тогтоолын дагуу үе шаттайгаар Төрийн сангийн нэгдсэн дансанд ЭМДС-н мөнгөн хөрөнгийг төвлөрүүлсэн. | Даатгалын сангийн эрсдэлд орсон мөнгөн хөрөнгийг төрийн санд төвлөрүүлэх, авлага барагдуулах чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. | Капитал банкнаас 136.1 тэрбум төгрөгийн авлагаас 2025 оны 05 дугаар сарын 20-ны байдлаар тус банкны эрх хүлээн авагч 13.7 тэрбум төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлсэн. Мөн 46.7 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгө хүлээн авч үүнээс 11.2 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг борлуулалж эрүүл мэндийн даатгалын санд төвлөрч, Капитал банкнаас авах авлага 75.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.<br>Капитал банкны эрх хүлээн авагчаас нийт 52 объектийн 46.7 тэрбум төгрөгийн хөрөнгийг хүлээн авсан. Өнөөдрийн байдлаар 39 объектийн 11.7 тэрбум төгрөгийн хөрөнгийг борлуулж Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлсэн.<br>2025 онд 607,4 сая төгрөгийн хөрөнгө борлуулсан байна. Мөн Капиталын эрх хүлээн авагчаас 400,0 сая төгрөгийн авлага барагдуулсан.<br>Эрх хүлээн авагчаас хүлээн авсан хөрөнгөөс 13 объектийн 35.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь Капитал банкнаас хүлээн авсан үл хөдлөх хөрөнгийг түрээслэж 2025 оны 05 дугаар сарын 20-ний байдлаар 118.8 сая төгрөгийн орлогыг Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлээд байна<br>Эрүүл мэндийн даатгалын сангийн 30.9 тэрбум төгрөг Чингэс хаан банканд байршиж байгаа бөгөөд мөнгөн хөрөнгө эргэн төлөгдөхгүй эрсдэлтэй байдал үүссэн. Чингэс хаан банкнаас 2025 оны 05 дүгээр сарын 20-ны байдлаар 935.3 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлээд байна.<br>Үр дүн: Холбогдох газрууд руу албан бичиг хүргүүлж байна. | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.2 | *МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7,* БСТ-2.2.2 Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн зарцуулах журам, чөлөөт үлдэгдлийн журмыг ЭМДҮЗ-ийн тогтоолоор шинэчлэнбатлуулна. | - | Шинэчлэн батлагдсан тогтоол | ЭМДҮЗ-ийн 2021 оны 10 дугаар тогтоолыг мөрдөж байна. | Журам шинэчлэгдэн батлагдсан байна. | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн "Эрүүл мэндийн даатгалын 2024 оны эрсдэлийн сангийн хөрөнгийг зарцуулах тухай" 16 тогтоол батлагдсан.<br>Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны эрсдэлийн сангийн хөрөнгө 53.5 тэрбум төгрөгийг 2024 онд эрүүл мэндийн байгууллагын даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээнд зарцуулсан болно.<br><br>Үр дүн: Хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 90 |
| 2.2.3 | ЭМБ-д олгосон санхүүжилтийн мэдээллийг Дашбоардад татаж оруулах. | - | Дашбоардад байршсан санхүүжилтийн мэдээлэл. | | ЭМБ-д олгосон санхүүжилтийн мэдээллийг дашбоардад байршсан байна. | Эрүүл мэндийн даатгалын сангаас тусламж, үйлчилгээний санхүүжилт авсан эрүүл мэндийн байгууллагуудын олгосон санхүүжилтийн нэгтгэлийг DASH WORD програмд 2022-2024 оны оруулахаар олгосон, олгохоор тооцсон санхүүжилтийн мэдээллийг EXCEL файл бэлдэн БТГазарт хүргүүлсэн.<br>Мөн ЭМДС-ийн орлого, зарлага, төсвийн гүйцэтгэлд Fiscus программаар хяналт тавих, дашборд хөрвүүлэхээр БТГ, МТХ хамтран ажиллахаар төлөвлөж байна.<br><br>Үр дүн: Дашборд хөгжүүлж, олон нийтэд мэдээлэл хүргүүлэх | 70 |
| 3.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 3: Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна. | | | | | | | |
| 3.1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1-т заасан "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн чанарт үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авч, чанарын хяналтыг сайжруулна" зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 3.1.1 | МУТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.2, СТ 3.1.3 Стратегийн худалдан авалтын тогтолцооны | ЭМДС | Зарлагын дүн (тэрбум төгрөг) | ЭМДС-ийн зарлага 2017.9 тэрбум төгрөг | ЭМДС-н зарлага 2293.9 тэрбум төгрөг | Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагыг 2293.9 тэрбум төгрөг бөгөөд үүнээс эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан тусламж, | |

<table>
<tr>
<td></td>
<td>хүрээнд ЭМБ-уудын хянагдсан гүйцэтгэлийг хянаж, санхүүжүүлэх ажлыг зохион байгуулна</td>
<td></td>
<td>Гүйцэтгэлийн дүн</td>
<td>Гүйцэтгэл 108.0 хувь</td>
<td>Гүйцэтгэлийн хувь тооцож ажилласан байна.</td>
<td>үйлчилгээний 2275.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг даатгалын гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний зардалд зарцуулахаар баталсан. 2025 оны 04 дүгээр сарын 30-ний байдлаар тусламж, үйлчилгээний зардалд 899.2 тэрбум төгрөгийг даатгалын сангаас олгосон байна. Нийт 18830 удаагийн гүйлгээний бичилт хийгдсэн байна.<br>
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА /тэрбум төгрөг/
<table>
<tr><th>№</th><th>Үзүүлэлтийн нэр</th><th>Төлөвлөгөө</th><th>Төсвийн гүйцэтгэл</th></tr>
<tr><td>1</td><td>ЭМДСангаас эмийн үнийн хөнгөлөлт</td><td>60.3</td><td>60.5</td></tr>
<tr><td>2</td><td>Улсын төсвийн санхүүжилт Анхан шат</td><td>709.3</td><td>144.8</td></tr>
<tr><td>3</td><td>ЭМДСангийн санхүүжилт</td><td>709.3</td><td>691.8</td></tr>
<tr><td>4</td><td>ЭМДШ-н илүү төлөлтийн буцаалт</td><td>0.05</td><td>0.001</td></tr>
<tr><td>5</td><td>ҮА-ны зардал</td><td>4.4</td><td>3.0</td></tr>
<tr><td>6</td><td>Эргэж төлөгдөх зээл</td><td></td><td>-0.9</td></tr>
<tr><td colspan="2">НИЙТ ДҮН</td><td>919.0</td><td>899.2</td></tr>
</table>
Үр дүн: Тусламж, үйлчилгээний зардлыг ЭМДС-с олгосон байна.</td>
<td>80</td>
</tr>
<tr>
<td>3.1.2</td>
<td>БГТ-3.2.3 Гэрээт эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ</td>
<td>-</td>
<td>Зөвхөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгууллагын тоо</td>
<td>-</td>
<td>Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна.</td>
<td>Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээтэй Эрүүл мэндийн байгууллагуудад олгосон санхүүжилт болон олгохоор тооцсон гүйцэтгэлийн талаар гомдол санал ирсэн тохиолдолд цаг тухайд нь мэдээллийг хүргэж ажиллаж байна .<br><br>Үр дүн Мэргэжил арга зүйгээр ханган ажилласан.</td>
<td>90</td>
</tr>
<tr>
<td>3.1.3</td>
<td>БГТ-3.2.3 Орон нутаг дахь эрүүл мэндийн даатгалын зарим</td>
<td>-</td>
<td>Хяналт шалгалт, хяналт шинжилгээ</td>
<td>-</td>
<td>Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаанд иж</td>
<td>Аймаг, дүүргийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэсүүдээс ЭМБ-н хянагдсан гүйцэтгэлийг хүлээн авч хянан илэрсэн алдаа дутагдалыг тухай бүрт зөвлөн залруулж, тайлан мэдээ болон</td>
<td>90</td>
</tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэлтсийн үйл ажиллагаанд иж бүрэн хяналт шалгалт, хяналт шинжилгээ хийж, зөвлөн туслана. | | нийсэн нэгжийн тоо | | бүрэн хяналт шалгалт, хяналт шинжилгээ хийгдсэн байна. | олгосон санхүүжилт, тогтоол журмын талаар мэргэжил арга зүйгээр ханган зөвлөн туслан ажиллаж байна.<br><br>Үр дүн Мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. | |

4.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 4: Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.

4.1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1-т заасан "Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжинө" зорилтын хүрээнд:

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.1 | ЭМДЕГ-тай гэрээтэй ЭМБ-уудад Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилтийг ил тодоор мэдээлнэ. | - | Мэдээллийн тоо | ЭМДС-с ЭМБ-д олгосон санхүүжилтийн мэдээллийг 12 удаа олон нийтийн сайтад байршуулсан. | Тайлант онд мэдээллийг 12-оос доошгүй удаа байршуулсан байна. | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авч байгаа эрүүл мэндийн байгууллагуудын олгосон санхүүжилтийн тоо мэдээг сар бүрийн 30-ний байдлаар тусламж, үйлчилгээ бүрээр гарган ОНХХэлтэст хүргүүлж байна.<br>Засгийн газрын 2022 оны 232 тогтоолын хавсралтаар баталсан "Нээлттэй өгөгдлийн жагсаалт"ыг үндэслэн гарсан ЭМДЕГ-н даргын 2023 "Төлөвлөгөө батлах тухай" А/48 тушаалын дагуу нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэг үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу мэдээллийг байршуулсан.<br><br>Үр дүн: Холбогдох мэдээ, мэдээллийг цаг тухайд нь байршуулж байна. | 90 |
| 4.1.2 | Хэрэглэгчтэй харилцах төвийн 1800-1363 лавлах утсанд хандсан даатгуулагч-иргэдэд эрүүл мэндийн даатгалын талаарх зөвлөгөө, мэдээллийг хүргэж санал гомдлыг шийдвэрлэнэ. | - | Шийдвэрлэлт ийн хувь | Хэрэглэгчтэй харилцах төв 1800-1363 утсанд хандсан 150 гаруй шимтгэл төлөлтийн талаарх хүсэлт, гомдол болон санхүүжилттэй холбоотой мэдээ мэдээллийг шийдвэрлэсэн. | Шимтгэл төлөлтийн талаарх хүсэлт, гомдлыг 100 хувь шийдвэрлэсэн байна. | Олон нийттэй харилцах хэлтэсийн 1800-1363 утсанд ирсэн. Хоригдолуудын шимтгэл төлөлтийн талаарх хүсэлт, гомдлыг холбогдох мэргэжилтэн, хорих ангиудтай холбоо барин асуудлыг тухай бүр шийдвэрлэсэн.<br><br>Үр дүн: Санал гомдол, санал хүсэлтийг цаг тухайд шийдвэрлэсэн. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.3 | Даатгуулагчдын гомдол, санал, хүсэлтэд дүн шинжилгээ хийх, гомдол, саналыг бууруулах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулах мэргэжил арга зүйгээр хангана. | - | Шийдвэрлэлтийн хувь | Даатгуулагчийн шимтгэлтэй холбоотой нийт-3357 өргөдөл гомдолын 237.2 сая төгрөгийн буцаан олголтыг олгосон байна. | Даатгуулагчийн буцаан олголтыг цаг тухайд 100 хувь олгосон байна. | Нийгмийн даатгалын хуулийн өөрчлөлтийн дагуу Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.2.хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, 6.1.3.малчин, 6.1.4.энэ хуулийн 4.4-т заасан гадаадын иргэн, харьяалалгүй хүн, 6.1.9.их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч, 6.1.12.энэ хуулийн 6.1.1-6.1.11-д зааснаас бусад иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг ЭМДЕГазар нь 2024 оны 01 сараас цуглуулж, төвлөрүүлэхээр болсон. Тус хуулийн 6.1.1-6.1.10 ангилагдсан шимтгэл төлөх даатгуулагчийн шимтгэлийг Цахим төлбөрийн баримт (ebarimt.mn) хүлээн авч ноогдуулалтыг хийж байна.<br>Шимтгэл бүрдүүлэх явцад зарим даатгуулагч данс зөрүүлсэн, цахим төлбөрийн баримтаар (ebarimt.mn) шимтгэл төлөх боломжгүй, регистрийн дугаараа андуурч оруулсан, даатгуулагчийн ангилал өөрчлөгдсөн нэр регистр буруу, илүү болон давхар төлбөр төлсөн зэрэг иргэд даатгуулагчаас өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэж байна.<br>2025 оны 01 сарын 01-ээс 05 дугаар сарын 20-ны байдлаар **НИЙТ-869** иргэний өргөдөл ирсэн байна. Энэ хугацаанд **НИЙТ-856** иргэний **41.7** сая төгрөгийн буцаан олголтыг олгосон байна. Өргөдөлийн шийдвэрлэлт **98.5** хувьтай байна. Өргөдлийн материал дутуу, дансны дугаар зөрүүтэй өргөдлийн асуудлыг тухайн иргэнтэй холбогдож дутуу мэдээллийг хүлээн авч цаг тухайд нь асуудлыг шийдвэрлэж ажилласан.<br><br>Үр дүн: Санал гомдол, санал хүсэлтийг цаг тухайд шийдвэрлэсэн | 90 |
| 4.1.4 | Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлэх ажлыг | - | Архивын нэгжийн тоо (боть) | 495 боть | Хадгаламжийн нэгжийг архивын стандартын дагуу эмхэлж цэгцлэн, үдэж, хавтаслан байгууллагын | Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн зардлын гүйцэтгэл, төсвийн гүйцэтгэлийн мэдээ,тайлан, иргэдийн өргөдөл, төлбөр төлсөн баримт НИЙТ-495 боть баримтыг ТГ-н архивын мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн. Үүнд: | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулна. | | | | архивт хүлээлгэн өгсөн байна. | ➢ Зардлын гүйцэтгэл, тооцоо нийлсэн акт-445 боть<br>➢ Иргэдийн өргөдөл, төлбөр төлсөн баримт-43<br>➢ Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн мэдээ-7<br>Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн зардлын баримт болон бусад баримтыг архивын боть болгон цэгцэлж байна.<br>Үр дүн: Цаг хугацаанд нь архивын баримтыг хүлээлгэн өгсөн. | 90 |
| 4.1.5 | Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, албан хаагчдын баримтлах ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангуулна. | - | Хэрэгжилтийн хувь | 100 хувь | Бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна. | Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, албан хаагчдын баримтлах ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг ханган ажилласан.<br><br>Үр дүн: Ёс зүйн хэм хэмжээг баримтлан ёс зүйн зөрчилгүй ажилласан. | 100 |
| 4.1.6 | Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэн, зөв, бүрэн байршуулсан эсэхэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулна. | - | Мэдээллийн тоо | 2024 онд шилэн дансанд НИЙТ-12440 гүйлгээг байршуулсан байна. | 13,0 мянгаас доошгүй гүйлгээг оруулсан байна | ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/40 дүгээр тушаалаар Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд байршуулах албан хаагчдын хуваарийг баталсан бөгөөд хуваарийн дагуу шилэн дансанд урсгал үйл ажиллагааны тайлан, сарын мэдээ, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй гүйлгээ зэрэг иргэн, олон нийтэд ил тод нээлттэй байх төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнах шилэн дансны цэсэд хууль тогтоомжид заасан хугацаанд оруулан ажиллаж байна. 2025 оны 04 дүгээр сарын 30-ны байдлаар зарлагын 7200 гаруй гүйлгээг шилэн дансанд байршуулсан.<br>Үр дүн: Хуулийн хугацаанд мэдээллийг байршуулсан байна. | 90 |

*Төлөвлөгөөг үнэлсэн:* **Төсвийн шууд захирагч**

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА.............................(С.ЭНХБОЛД)

......................*(огноо)*

*Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:* **Нэгжийн дарга**

ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА...........................................................................(Б.ОЮУНЦЭЦЭГ)

2025.06.24 ..............................*(огноо)*

*Тайлагнасан:* **Нэгжийн дарга**

САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА ................................................... (Ч.ГАНТӨМӨР)

2025.05.21 (огноо)

УЖА0067
6263305 1118156030